



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 253

Улаанбаатар хот

┌ Албан журмын даатгагчдын холбооны удирдах ┐
зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12¹ дугаар зүйлийн 12^{1.2} дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл Л. Сонорыг чөлөөлсүгэй.


2. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөр Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн ахлах шинжээч Н.Түвшинжаргалыг баталсугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 433 дугаар тогтоолын хавсралтад заасан Л.Сонортой холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

4. Даатгалын тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг шинээр батлагдсан гишүүн /Н.Түвшинжаргал/-д үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН